



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн долоодугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/200/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.08.28 № 1-С/131

танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮҮХДИЙН
ДОЛООДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.БОЛОРТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-үүд сумын хүүхдийн Долоодугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-үүд сумын хүүхдийн Долоодугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	131.1	138.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,575.4	1,561.3
	Нийт хөрөнгийн дүн	1,706.5	1,699.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,706.5	1,699.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,706.5	1,699.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,856.5	399.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	150.0	420.6
	Үйл ажиллагааны үр дүн	1,706.5	(20.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,706.5	(20.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,706.5
	Тайлант оны үр дүн	-	(20.7)
	Эцсийн үлдэгдэл	1,706.5	1,699.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	205.2	386.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	191.9	363.2
	Үйл ажиллагааны ЦМГ	13.3	22.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(13.3)	(22.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	412.4	385.5
	Урсгал зардал	412.4	385.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	412.4	385.5
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344.3	344.3
	Орон нутгийн төсвөөс	68.2	41.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Замын-Үүд сумын Хүүхдийн долоодугаар цэцэрлэг нь 2021-2022 оны хичээлийн жилд “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын дэмжлэг, хамтын ажиллагаа, оролцоог ханган, хичээл сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах” зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2014 оноос “Ухаалаг багачууд” нэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг хувийн цэцэрлэг байсан. Төсвийн 1,637.0 сая төгрөгөөр 2020 оны 9 сард худалдаж авч үйл ажиллагааг нь дахин шинээр эхлүүлсэн байна. Барилга байгууламжийг 14,461.9 сая төгрөг, машин тоног төхөөрөмжүүдийг 53.4 сая төгрөг, тавилгыг 66.3 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгийг 55.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр тус тус үнэлэн худалдан авч тайлан баланст бүртгэсэн байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 369.4 сая төгрөгийн 29 орлогын гүйлгээ, 19.1 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, 19.1 сая төгрөгийн 2 худалдан авах ажиллагаа, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 16 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 2 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан байна. Үүнд өмч хөрөнгө, төсөв зарцуулах 2 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Залруулсан алдаа:

1. Нийт 1.1 сая төгрөгийн бараа материалыг дансны бүртгэлийг буруу ангилалд бүртгэснийг аудитын явцад залруулав.
2. Санхүүгийн байдлын тайлангийн бусад үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 0.03 сая төгрөгөөр дутуу байсныг аудитын явцад залруулж 0.03 сая төгрөгөөр нэмэгдүүлж өмнөх үеийн үр дүнг тус дүнгээр өсгөж залруулав.

Албан шаардлага:

1. Тус байгууллагын албан хаагч Гантулгын 8 сард олгосон цалингаас 0.3 сая төгрөгийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	1.4	2	1.1	-	-	1	0.3	-	-
	НИЙТ	3	1.4	2	1.1	-	-	1	0.3	-	-